



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/639

Ховд

Гэр хороолол дунд таунхаус зохион байгуулалттай, цөөн айлын жишиг сууцны төсөл хэрэгжүүлэхэд дэд бүтцийн асуудлыг шийдэх ажлыг хүлээн авах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын "б", Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 1 дүгээр хавсралтын 1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар "Алтан орд констракшн" ХХК-ийн хийж гүйцэтгэсэн Гэр хороолол дунд таунхаус зохион байгуулалттай, цөөн айлын жишиг сууцны төсөл хэрэгжүүлэхэд дэд бүтцийн асуудлыг шийдэх ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Б.Баярсүх

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд: Н.Цацралцэцэг

- Мэргэжлийн хяналтын газрын эрчим хүчний хяналтын Улсын байцаагч

Д.Нямтулга

- Мэргэжлийн хяналтын газрын барилгын техникийн хяналтын улсын байцаагч

Б.Түмэндэмбэрэл

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Б.Туулайтулга

- Жаргалант сумын Засаг даргын орлогч

3.Өмиртай

- Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга

- М.Нансалмаа - “Шим-Ус” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын ерөнхий инженер
- Н.Ням-Эрдэнэ - “Ховд цахилгаан түгээх сүлжээ”ХХК-ий Ерөнхий инженер
- Ц.Цолмонбаатар - Стандарт хэмжилзүйн хэлтсийн салбар сан хариуцсан мэргэжилтэн
- Ц.Даваасамбуу - Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн
- С.Батдорж - Аймгийн архивын тасгийн дарга
- Э.Алтан-Од - “Алтан орд констракшн” ХХК-ийн захирал
- Нарийн бичгийн дарга: С.Өнөржаргал - Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн

2. “Алтан орд констракшн” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган шалгаж, өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН